

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС, БҮГД  
НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ХООРОНДЫН  
КОНСУЛЫН КОНВЕНЦ

Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Монгол Ард  
Улс,

хоёр улсын хоорондын найрамдал, хамтын ажиллагаа, сайн  
хөршийн харилцааг хөгжүүлэх эрмэлзлийг удирдлага болгон, кон-  
сулын харилцааг бэхжүүлэх, тус хоёр улсын улс, иргэдийн эрх  
ашгийг хамгаалах зорилгоор

энэхүү Консулын Конвенцийг байгуулахаар шийдвэрлэж дор  
дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.Үүнд:

I ХЭСЭГ

ТОДОРХОЙЛОЛТ

Нэгдүгээр зүйл

Энэхүү Конвенцэд гарах дор дурдсан нэр томъёог дараах  
утгаар ойлгоно:

а/"консулын газар" гэж ерөнхий консулын газар, кон-  
сулын газар, дэд консулын газар, консулын төлөөлөгчийн газ-  
рыг тус тус хэлнэ.

б/"консулын тойрог" гэж консулын газар консулын албан  
үүргээ гүйцэтгэхэд зориулан тогтоосон районыг хэлнэ.

в/"консулын газрын тэргүүн" гэж консулын газрыг удир-  
даж байгаа ерөнхий консул, консул, дэд консул, консулын тө-  
лөөлөгчийг хэлнэ.

г/"консулын албан тушаалтан" гэж консулын газрын тэр-  
гүүнийг оролцуулан ерөнхий консул, ерөнхий консулын орлогч,  
консул, дэд консул, консулын атташе, консулын төлөөлөгчийг  
хэлнэ.

д/"консулын газрын ажилтан" гэж консулын албан тушаалтан биш боловч консулын газарт захиргаа, техникийн буюу үйлчилгээний ажил үүрэг гүйцэтгэж буй хүмүүсийг хэлнэ.

е/"консулын газрын гишүүд" гэж консулын албан тушаалтан болон консулын газрын ажилтнуудыг хэлнэ.

ж/"гэр бүлийн гишүүд" гэж консулын албан тушаалтан, консулын газрын ажилтнуудын хамт амьдарч байгаа тэдний гэргий буюу нөхөр, насанд хүрээгүй хүүхдийг хэлнэ.

з/"консулын газрын байр" гэж хэн өмчлөх эрхтэйг үл харгалзан гагцхүү консулын зорилгод ашиглаж буй барилга, барилгын хэсэг, тэдгээрт хамаарах газрыг хэлнэ.

и/"консулын архив" гэж консулын газрын бүх захидал, харилцаа, бичиг баримт, шифр, код, тамга, соронзон бичлэгийн хальс, видео бичлэгийн хальс, гэрэл зургийн хальс, фото зураг, бүртгэл, ном болон тэдгээрийг хадгалж хамгаалахад зориулсан тавилга төхөөрөмжийг хэлнэ.

к/"томилогч улсын агаарын хөлөг" гэж томилогч улсад бүртгэлтэй, түүний таних тэмдэг бүхий нисэх аппаратыг хэлнэ.Цэргийн агаарын хөлөг үүнд хамаарагдахгүй.

л/"томилогч улсын хөлөг онгоц" гэж томилогч улсын хууль тогтоомжийн дагуу өөрийн улсын далбааг мандуулсан усан онгоцыг хэлнэ.Цэргийн хөлөг онгоц үүнд хамаарагдахгүй.

м/"томилогч улсын иргэн" гэж томилогч улсын иргэний харьяалалтай бие хүн, мөн түүнчлэн утгаараа тохирч байвал томилогч улсын хуулийн этгээдийг хэлнэ.

## II ХЭСЭГ

### КОНСУЛЫН ГАЗРЫГ БАЙГУУЛАХ, КОНСУЛЫН ГАЗРЫН ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ

Хоёрдугаар зүйл

#### Консулын газрыг байгуулах, консулын газрын тэргүүнийг томилох

1. Консулын газрыг хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дээр гагцхүү тэр улсын зөвшөөрлөөр байгуулна.

2. Консулын газрын байрлах газар, түүний зэрэг, консулын тойрог болон тэдгээрийн цаашдын өөрчлөлтийг томилогч улс болон хүлээн авагч улс тохиролцсоноор тогтооно.

3. Томилогч улс консулын газрынхаа тэргүүнийг томилохын өмнө уг хүнийг томилох зөвшөөрлийг хүлээн авагч улсаас дипломат шугамаар асууна.

Хэрэв хүлээн авагч улс түүнийг томилохыг зөвшөөрөхгүй бол шалтгааныг тайлбарлах үүрэггүй.

4. Томилогч улс зохих зөвшөөрөл авсны дараа консулын газрынхаа тэргүүнийг томилсон тухай консулын патентыг өөрийн улсын дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан хүлээн авагч улсын Гадаад явдлын Яаманд илгээнэ. Патентад консулын газрын тэргүүний овог, нэр, зэрэг, албан тушаал, консулын тойрог болон консулын газрын байрлах газрыг заасан байх ёстой.

5. Консулын газрын тэргүүнийг томилсон тухай патентыг хүлээн авагч улс хүлээн авмагц аль болох богино хугацаанд консулын экзекватурыг үнэ төлбөргүй олгоно.

6. Хүлээн авагч улсаас экзекватур олгомогц консулын газрын тэргүүн албан үүргээ гүйцэтгэж эхэлнэ.

7. Хүлээн авагч улс экзекватур олгохын өмнө консулын газ-

рын тэргүүнд албан үүргээ гүйцэтгэж байх түр зөвшөөрөл олгож болно.

8. Хүлээн авагч улс консулын газрын тэргүүнийг хүлээн зөвшөөрсөн буюу түүнд албан үүргээ түр гүйцэтгэж байх зөвшөөрөл олгомогц энэ тухайгаа консулын тойргийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх ёстой. Консулын газрын тэргүүн албан үүргээ гүйцэтгэх, энэхүү Конвенцад заасан эрх, эрх ямба, халдашгүй эрх эдлэхэд нь хүлээн авагч улс шаардагдах бүх арга хэмжээ авах ёстой.

9. Консулын газрын тэргүүн ямар нэг шалтгаанаар үүрэгт ажлаа гүйцэтгэж чадахгүй болох буюу түүнийг түр эзгүй үед томилогч улс консулын газрын тэргүүний үүргийг гүйцэтгэх эрхийг тухайн консулын газрын аль нэг албан тушаалтанд буюу дипломат төлөөлөгчийн газрын дипломат бүрэлдэхүүний аль нэг гишүүнд олгож болно. Консулын газрын тэргүүний үүргийг түр гүйцэтгэх хүний овог, нэр, зэрэг, албан тушаалыг хүлээн авагч улсын Гадаад явдлын Яаманд бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

10. Консулын газрын тэргүүний үүргийг гүйцэтгэгч энэхүү Конвенцийн заалтын дагуу консулын газрын тэргүүний эдлэх эрх, эрх ямба, халдашгүй эрхийг эдэлнэ.

11. Томилогч улсын дипломат төлөөлөгчийн газрын дипломат бүрэлдэхүүний гишүүдийн аль нэгийг энэ зүйлийн 9-д дурдсаны дагуу консулын газрын тэргүүний үүрэг гүйцэтгэгчээр томилоход дипломатын хувьд түүнд олгосон эрх, эрх ямба, халдашгүй эрхийг хэвээр эдлүүлнэ.

Гуравдугаар зүйл

Консулын газрын гишүүнийг  
ТОМИЛОХ

I. Томилогч улс консулын газрын тэргүүнээс бусад консулын газрын гишүүдийн овог, нэр, зэрэг, албан тушаал, хүрэлцэн

ирэх, бүрмөсөн буцах болон албан үүргийг нь зогсоох, мөн консулын газарт албан үүргээ гүйцэтгэх үед нь гарсан аливаа өөрчлөлтийг хүлээн авагч улсын Гадаад явдлын Яаманд бичгээр мэдэгдэж байна.

2.Томилогч улс консулын газрын гишүүний гэр бүлийн гишүүдийн овог, нэр, иргэний харьяалал болон хүрэлцэн ирэх, бүрмөсөн буцах, мөн аль нэг хүн гэр бүлийн гишүүн болсон, эсвэл гэр бүлийн гишүүн байхаа больсон тухай хүлээн авагч улсын Гадаад явдлын Яаманд мэдэгдэнэ.

3.Хүлээн авагч улс консулын газрын гишүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд зохих бичиг баримт олгоно.Энэ заалт нь хүлээн авагч улсын иргэн буюу тэр улсад байнга оршин суугчид хамаарахгүй.

4.Консулын албан тушаалтан нь хүлээн авагч улсад байнга оршин суугч биш, гагцхүү томилогч улсын иргэд байна.

5.Хэлэлцэн тохирогч хоёр Тал консулын газрын гишүүдийн тоог харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр тогтооно.

Дөрөвдүгээр зүйл

Дипломат төлөөлөгчийн газар консулын үүрэг гүйцэтгэх

1.Томилогч улсаас хүлээн авагч улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар консулын үүрэг гүйцэтгэж болно.Томилогч улсын дипломат төлөөлөгчийн газар консулын үүрэг гүйцэтгэх дипломат бүрэлдэхүүний гишүүдийн овог, нэр, зэрэг, албан тушаалыг хүлээн авагч улсын Гадаад явдлын Яаманд мэдэгдэнэ.

2.Консулын үүрэг гүйцэтгэх дипломат бүрэлдэхүүний гишүүд энэхүү Конвенцэд заасан консулын албан тушаалтны эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3. Дипломат төлөөлөгчийн газрын консулын үүрэг гүйцэтгэх дипломат бүрэлдэхүүний гишүүд дипломатын хувьд тэдэнд олгосон эрх, эрх ямба, халдашгүй эрхийг хэвээр эдэлнэ.

Тавдугаар зүйл

Консулын газрын гишүүний үйл  
ажиллагааг зогсоох

Томилогч улсын консулын газрын тэргүүнд олгосон экзекватураа эгүүлэн авах тухай, түүнчлэн консулын газрын гишүүнийг тааламжгүй этгээд гэж үзсэн тухайгаа хүлээн авагч улс шалтгааныг тусгайлан тайлбарлахгүйгээр томилогч улсад дипломат шугамаар хэдийд ч мэдэгдэж болно.

Консулын газрын гишүүн үүрэгт ажилдаа орсон үед ийм тохиолдол гарвал томилогч улс уг хүнийг татан дуудах ёстой. Хэрэв томилогч улс үүнийг зохих хугацаанд гүйцэтгэхгүй бол хүлээн авагч улс түүнийг консулын газрын гишүүн гэж хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж болно.

III ХЭСЭГ

ЭРХ, ЭРХ ЯМБА, ХАЛДАШГҮЙ ЭРХ

Зургадугаар зүйл

Консулын газарт зориулж газар түрээслэх,  
байр орон сууц худалдан авах буюу хөлс-  
лөн авах

I. Томилогч улсын консулын газрын байр, консулын газрын гишүүдийн орон сууцанд зориулж хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу газрыг түрээсээр, барилга, барилгын хэсгийг худалдаж авах буюу хөлслөн авах, барих, мөн бусад арга замаар олж авч болно. Гэвч консулын газрын ажилтан нь хүлээн авагч улсын иргэн буюу тэр улсад байнга оршин суугч бол энэ заалт түүний орон сууцанд хамаарахгүй.

Энэ заалтыг хэрэгжүүлэхэд хүлээн авагч улс томилогч улсад туслалцаа үзүүлнэ.

2.Энэ зүйлийн I-д заасан газар, барилга, барилгын хэсэг байгаа районд барилга барих болон хотын төлөвлөлттэй холбогдох хууль тогтоомжийг биелүүлэх үүргээс томилогч улсыг чөлөөлөхгүй.

#### Долдугаар зүйл

#### Консулын газрын ажлын нөхцөл, консулын албан тушаалтныг хамгаалах

1.Консулын газар албан үүргээ хэвийн байдлаар гүйцэтгэхэд шаардагдах бүхий л арга хэмжээг хүлээн авагч улс авах ёстой.

2.Хүлээн авагч улс томилогч улсын консулын албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх, энэхүү Конвенцэд болон хүлээн авагч улсын хууль тогтоомжид заасан эрх, эрх ямба, халдашгүй эрхийг бүрэн эдлэхэд нь шаардагдах бүхий л арга хэмжээг авна.

3.Хүлээн авагч улс томилогч улсын консулын албан тушаалтанд хүндэтгэл үзүүлэхээс гадна тэдний бие, эрх чөлөөнд халдах, нэр төрийг нь гутаахаас урьдчилан сэргийлэх бүх талын зохих арга хэмжээ авах үүрэгтэй.

4.Консулын албан тушаалтан халдашгүй эрх эдэлнэ.Түүнийг ямар нэг хэлбэрээр саатуулах буюу баривчилж үл болно.

#### Наймдугаар зүйл

#### Улсын сүлд, далбаа

1.Томилогч улс өөрийн улсын сүлд, томилогч улсын болон хүлээн авагч улсын хэл дээр бичсэн консулын газрын хаягийг консулын газрын байрны гадна хадаж болно.

2.Томилогч улсын төрийн далбааг консулын газрын байр

болон консулын газрын тэргүүний өргөөнд мандуулж болно.

3. Консулын газрын тэргүүн албан үүргээ гүйцэтгэж явахдаа өөрийн тээврийн хэрэгсэлд улсынхаа төрийн далбааг мандуулж болно.

Есдүгээр зүйл

Консулын газрын байр, орон сууцны  
халдашгүй эрх

1. Консулын газрын байр халдашгүй байна. Консулын газрын тэргүүн буюу томилогч улсын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, эсвэл тэдний аль нэгний нэр заасан хүний зөвшөөрөлгүйгээр консулын газрын байранд хүлээн авагч улсын албаны хүмүүс нэвтрэн орж үл болно.

2. Энэ зүйлийн I-ийн заалт консулын газрын гишүүдийн орон сууцанд нэгэн адил хамаарна.

3. Хүлээн авагч улс консулын газрын байранд халдах буюу хохирол учруулахаас хамгаалах, консулын газрын тайван байдлыг алдагдуулах, нэр төрийг гутаахаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээ авах үүрэгтэй.

Аравдугаар зүйл

Консулын архивын халдашгүй  
эрх

Консулын архивт хаана ч, хэдийд ч халдаж үл болно. Албаны бус бичиг баримт, эд юмс консулын архивт хадгалагдах ёсгүй.

Арван нэгдүгээр зүйл

Чөлөөтэй харилцах эрх

I. Консулын газар өөрийн улсын Засгийн газар, дипломат төлөөлөгчдийн газар болон бусад консулын газартайгаа чөлөө-

тэй харилцах эрхтэй. Консулын газар энэ зорилгоор холбооны ердийн хэрэгсэл, дипломат болон консулын элч, шифр, кодын мэдээ, дипломат болон консулын шууданг ашиглаж болно. Радио нэвтрүүлгийн хэрэгслийг гагцхүү хүлээн авагч улсын зөвшөөрлөөр байгуулж ашиглана.

2. Гадна талдаа шинжийг нь тодорхойлсон таних тэмдэг бүхий битүүмжилсэн консулын шуудан халдашгүй бөгөөд түүнийг хүлээн авагч улсын төрийн байгууллагаас задлан үзэх буюу саатуулж үл болно. Консулын шууданд гагцхүү албан бичиг баримт болон албан хэрэгцээнд зориулсан эд юмс байх ёстой.

3. Томилогч улсын консулын элч хүлээн авагч улсаас дипломат элчид олгодогтой адил эрх, эрх ямба, халдашгүй эрхийг эдэлнэ. Консулын элч нь хүлээн авагч улсад байнга оршин суугч биш, гагцхүү томилогч улсын иргэн байх бөгөөд түүний эрхийг нотолсон албан бичиг баримтыг авч явах ёстой.

4. Консулын шууданг өөрийн улсын агаарын хөлгийн даргад итгэмжлэн өгч болно. Түүнд шуудангийн тоог заасан албан ёсны бичиг баримт олгох ёстой бөгөөд түүнийг консулын элч гэж үзэхгүй, хүлээн авагч улсын холбогдох байгууллагатай тохиролцсоны дагуу консулын албан тушаалтан консулын шууданг агаарын хөлгийн даргаас шууд, саадгүйгээр гардан авах буюу мөн тийнхүү хүлээлгэн өгч болно.

Арван хоёрдугаар зүйл

#### Хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх

I. Консулын албан тушаалтан иргэний дор дурдсан нэхэмжлэлээс бусад хүлээн авагч улсын шүүхийн болон захиргааны хариуцлагаас чөлөөлөгдөх халдашгүй эрх эдэлнэ:

а/ томилогч улсын нэрийн өмнөөс консулын зорилгод эзэмшээгүй байгаа бол хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт байгаа хувийн үл хөдлөх хөрөнгөд хамаарагдах нэхэмжлэл,

б/өв залгамжлалын нэхэмжлэлд томилогч улсын нэрийн өмнөөс биш, хувийн журмаар гэрээслэл биелүүлэгч, өвлөх эд хөрөнгийг харгалзагч, өв залгамжлагч буюу өвийн хувь авагчаар оролцвол,

в/хүлээн авагч улсад өөрийн албан үүргээс гадуур гүйцэтгэж байгаа мэргэжлийн буюу худалдааны аливаа үйл ажиллагаатай холбогдсон нэхэмжлэл,

г/тэднээс томилогч улсын төлөөлөгчийн хувьд шууд буюу шууд бусаар үүрэг хүлээн авалгүйгээр байгуулсан гэрээтэй холбогдсон нэхэмжлэл,

д/хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт гарсан тээврийн хэрэгслийн ослоос болж учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр гуравдахь этгээдээс гаргасан нэхэмжлэл.

2.Хүлээн авагч улс энэ зүйлийн I-ийн "а", "б", "в", "г", "д"-д зааснаас бусад тохиолдолд консулын албан тушаалтанд аливаа гүйцэтгэх арга хэмжээ авахгүй бөгөөд дээрх тохиолдлуудад тэдний бие болон орон сууцны халцашгүй эрхийг зөрчихгүйгээр зохих арга хэмжээ авна.

3.Консулын газрын ажилтан албан үүргээ гүйцэтгэх үедээ хүлээн авагч улсын шүүхийн болон захиргааны хариуцлагаас чөлөөлөгдөнө.Гэвч энэ зүйлийн I-ийн "г", "д"-д дурдсан иргэний нэхэмжлэл хамаарахгүй.

Арван гуравдугаар зүйл

### Халцашгүй эрх эдлүүлэхээс татгалзах

I.Томилогч улс өөрийн консулын газрын гишүүн, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүдэд энэхүү Конвенцэд заасан аль нэг халцашгүй эрх эдлүүлэхээс татгалзаж болно.Ийнхүү татгалзаж байгаагаа ямар ч тохиолдолд бичгээр тодорхой илэрхийлсэн байх ёстой.

2.Энэхүү Конвенцийн дагуу хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх хүмүүс өөрөө хэрэг үүсгэсэн үед түүний үндсэн нэхэмжлэлтэй нь шууд холбоотой сөрөг нэхэмжлэл гарсан бол тэрээр хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх халдашгүй эрхээс иш татах эрхээ алдана.

3.Иргэний ба захиргааны хэргийн талаархи хариуцлагаас чөлөөтэй байх халдашгүй эрхээс татгалзах нь шийдвэр биелүүлэхээс чөлөөтэй байх халдашгүй эрхээс татгалзаж байгаа хэрэг биш бөгөөд үүний тулд жич татгалзах шаардлагатай.

Арван дөрөвдүгээр зүйл

Шүүхэд гэрчийн мэдүүлэг өгөхөөс  
чөлөөлөгдөх

1.Консулын албан тушаалтан хүлээн авагч улсын шүүх буюу эрх бүхий байгууллагад гэрчийн мэдүүлэг өгөх үүрэггүй.

2.Консулын газрын ажилтан хүлээн авагч улсын шүүх буюу эрх бүхий байгууллагад гэрчийн мэдүүлэг өгөхөөр дуудагдаж болно.

3.Консулын газрын ажилтан албан үйл ажиллагаагаа явуулахад хамаарах асуудлаар гэрчийн мэдүүлэг өгөх буюу холбогдох албан бичиг баримт өгөх үүрэггүй.Консулын газрын ажилтан шинжээчийн хувьд томилогч улсын хууль тогтоомжийг тайлбарлан тодорхойлсон мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй.Харин үүнээс бусад тохиолдолд консулын газрын ажилтан гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзаж болохгүй.

4.Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага консулын газрын ажилтнаас гэрчийн мэдүүлэг авахдаа түүний албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулахаас урьдчилан сэргийлэх ёстой.Боломжтой үед гэрчийн мэдүүлгийг бичгээр, эсвэл түүний орон сууцанд буюу консулын газрын байранд амаар авч болно.

Арван тавдугаар зүйл

Бүх төрлийн албадлагын үүргээс  
чөлөөлөгдөх

Консулын газрын гишүүд хүлээн авагч улсад цэргийн, хө-  
дөлмөрийн болон албадлагын бусад үүргээс чөлөөлөгдөнө.

Арван зургадугаар зүйл

Бүртгүүлэх, оршин суух зөвшөөрөл  
авахаас чөлөөлөгдөх

Консулын газрын гишүүд хүлээн авагч улсын хууль тогтоом-  
жид заасан гадаадын иргэд бүртгүүлэх, оршин суух зөвшөөрөл  
авах зэрэг бүх үүргийг биелүүлэхээс чөлөөлөгдөнө.

Арван долдугаар зүйл

Консулын газрын байр, консулын газрын  
гишүүдийн орон сууц, эд хөрөнгө татвар,  
хураамжаас чөлөөлөгдөх

1.Томилогч улсын нэрийн өмнөөс буюу тэр улсыг төлөөлсөн  
бие хүн хийгээд хуулийн этгээдийн өмнөөс түрээсэлсэн буюу  
худалдан авсан, барьсан консулын газрын байр, консулын газрын  
гишүүдийн орон сууц, тэдгээртэй холбогдсон худалдаа болон хэл-  
цэл, бичиг баримт аливаа татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

2.Энэ зүйлийн I-ийн заалт тодорхой төрлийн үйлчилгээний  
төлбөрт хамаарахгүй.

3.Консулын газрын хэрэгцээнд ашиглахаар томилогч улсаас  
оруулах бүх эд хөрөнгө, мөн дээрх зорилгоор худалдан авах эд  
хөрөнгөд хүлээн авагч улс аливаа татвар, хураамж ногдуулах-  
гүй.

Арван наймдугаар зүйл

Консулын газрын гишүүдийн хөдлөх  
өмч хөрөнгө татвар, хураамжаас  
чөлөөлөгдөх

Консулын газрын гишүүд хүлээн авагч улсын улс, орон нутгийн бүх төрлийн татвар, хураамж, тухайлбал тэдний хөдлөх өмч хөрөнгө нь татвар, хураамжаас чөлөөлөгдөнө. Ийнхүү чөлөөлөгдөх нь дараах зүйлст үл хамаарна:

а/энэхүү Конвенцийн 17 дугаар зүйлийн 1-ийн заалтад хамаарахгүй хүлээн авагч улсын нутагт байгаа амины үл хөдлөх хөрөнгөд ногдуулах татвар, хураамж,

б/энэхүү Конвенцийн 19 дүгээр зүйлийн 8-ын заалтын дагуу чөлөөлөгдөхөөс бусад хүлээн авагч улсын дотор байгаа эд хөрөнгийг өвлөх, шилжүүлэхэд ногдуулах татвар, хураамж,

в/хүлээн авагч улсад эх сурвалж нь байгаа албан үүргээс гадуурхи хувийн орлогоос авах татвар, хураамж,

г/энэхүү Конвенцийн 17 дугаар зүйлийн 1-ийн заалтын дагуу чөлөөлөгдөхөөс бусад хэлцэл, түүнийг хийхтэй холбогдсон бичиг баримтыг үйлдэхэд ногдуулдаг улсын бүх төрлийн татвар, хураамж,

д/тодорхой төрлийн үйлчилгээний хөлс,

е/барааны үнэ буку үйлчилгээний хөлсөнд ордог шууд бус татвар.

Арван есдүгээр зүйл

Гаалийн татвар, шалгалтаас чөлөө-  
лөгдөх

1. Консулын газрын албан хэрэгцээнд зориулсан бүх эд юмс, түүний дотор тээврийн хэрэгсэл нь дипломат төлөөлөгчийн газрын албан хэрэгцээнд зориулсан эд юмсын нэгэн адил гаалийн

татвараас чөлөөлөгдөнө.

2. Консулын газрын гишүүд, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүд дипломат төлөөлөгчийн газрын зохих зэргийн хүмүүсийн нэгэн адил гаалийн татвараас чөлөөлөгдөнө.

3. Энэ зүйлийн 2-т дурдсан "дипломат төлөөлөгчийн газрын зохих зэргийн хүмүүс" гэж консулын албан тушаалтны хувьд дипломат бүрэлдэхүүний гишүүдийг, консулын газрын ажилтны хувьд захиргаа, техникийн болон үйлчилгээний хүмүүсийг тус тус хэлнэ.

4. Консулын газрын гишүүдийн оруулж байгаа амины эд юмс тухайн хүний шууд хэрэгцээнээс хэтрэхгүй тоотой байна.

5. Консулын албан тушаалтны амины ачаа тээш гаалийн шалгалтаас чөлөөлөгдөнө. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага түүний ачаа тээшид хүлээн авагч улсын хууль тогтоомжоор оруулах, гаргахыг хориглосон эд юмс болон хорио цээрийн дүрмээр зохицуулагдах эд юмс байна гэж үзэх баттай үндэслэл байгаа бол шалгаж болно. Консулын холбогдох албан тушаалтан болон түүний төлөөлөгчийг газар дээр нь байлцуулан шалгалтыг хийх хэрэгтэй.

6. Энэ зүйлд заасан гаалийн татварт хадгаламж, тээвэр болон ийм төрлийн бусад үйлчилгээний хөлс хамаарахгүй.

7. Консулын газар, түүний гишүүд эд юмсыг оруулж, гаргахдаа оруулж гаргахыг хязгаарласан буюу хориглосон эд юмсын тухай хүлээн авагч улсын хууль тогтоомжийг зөрчиж болохгүй.

8. Консулын газрын гишүүн нас барвал хүлээн авагч улсад гагцхүү консулын газрын гишүүн байсантай холбогдуулан нас барагчийн тэр улсын нутаг дэвсгэрт байсан хөдлөх эд хөрөнгийг хүлээн авагч улсаас гаалийн татвар төлөхгүйгээр гаргахыг зөвшөөрч, мөн түүнчлэн өв залгамжлах буюу эд хөрөнгийг олж авах-

тай холбогдсон татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

Энэ заалт нь хүлээн авагч улсад худалдан авсан бөгөөд гаргахыг хязгаарласан буюу хориглосон эд хөрөнгөд хамаарахгүй.

Хорьдугаар зүйл

Чөлөөтэй зорчих

Улсын аюулгүй байдлыг хангах зорилгоор нэвтрэхийг хориглосон буюу хязгаарласан бүсээс бусад районд консулын газрын гишүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд консулын тойргийнхоо доктор чөлөөтэй зорчих эрхийг бүрэн хангана.

Хорин нэгдүгээр зүйл

Консулын хураамж

1. Консулын газар хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт консулын үйл ажиллагааг явуулж томилогч улсын хууль тогтоомжийн дагуу хураамж авна.

2. Энэ зүйлийн 1-д заасан консулын хураамж нь хүлээн авагч улсад бүх татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

Хорин хоёрдугаар зүйл

Гэр бүлийн гишүүдийн эрх ямба,  
халдашгүй эрх

Энэхүү Конвенцийн хорин гуравдугаар зүйлийн 2-т зааснаас бусад консулын албан тушаалтан, консулын газрын ажилтны гэр бүлийн гишүүд энэхүү Конвенциор консулын албан тушаалтан болон консулын газрын ажилтанд олгосон эрх ямба, халдашгүй эрх тус тус эдэлнэ.

Гэвч хүлээн авагч улсын иргэн буюу тэр улсад байнга оршин суугч энэхүү Конвенцэд заасан эрх ямба, халдашгүй эрх эдлэхгүй.

Хорин гуравдугаар зүйл

Эрх ямба, халдашгүй эрх эдлэхгүй  
хүмүүс

1. Хүлээн авагч улсын иргэн буюу тэр улсад байнга оршин суугч консулын газрын ажилтан энэхүү Конвенцэд заасан эрх ямба, халдашгүй эрх эдлэхгүй.

Гэвч арван дөрөвдүгээр зүйлийн 3-ын заалт үүнд хамаарахгүй.

2. Энэ зүйлийн 1-д заасан хүмүүсийн гэр бүлийн гишүүд энэхүү Конвенцэд заасан эрх ямба, халдашгүй эрх эдлэхгүй.

Хорин дөрөвдүгээр зүйл

Хүлээн авагч улсын хууль тогтоомжийг хүндэтгэх

1. Энэхүү Конвенцийн дагуу эрх ямба, халдашгүй эрх эдлэх хүн хүлээн авагч улсын хууль тогтоомж, түүний дотор тээврийн хэрэгслийг зохицуулж байгаа хууль тогтоомжийг өөрсдийн эрх ямба, халдашгүй эрхэд хохиролгүйгээр хүндэтгэх үүрэгтэй.

2. Консулын газар, консулын газрын гишүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд тээврийн хэрэгслийн даатгалын тухай хүлээн авагч улсын хууль тогтоомжийг баримтална.

IV ХЭСЭГ  
КОНСУЛЫН ҮҮРЭГ

Хорин тавдугаар зүйл

Консулын албан тушаалтны үйл ажиллагаа, үүрэг

1. Консулын албан тушаалтан томилогч улс, хүлээн авагч

улсын хоорондын найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд хоёр улсын эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, соёлын харилцааг өргөтгөхөд хүчин чармайлт гаргана.

2.Консулын албан тушаалтан хүлээн авагч улсын улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, биеийн тамирын болон бусад салбарын байдал, хөгжлийг хууль ёсны бүх арга замаар судалж тэдгээрийн тухай томилогч улсын Засгийн Газарт мэдээлнэ.

3.Консулын албан тушаалтан энэхүү Конвенцэд заасан үйл ажиллагаа, түүнчлэн хүлээн авагч улсын хууль тогтоомжид харшлахгүй бол консулын бусад үүргийг гүйцэтгэнэ.

4.Консулын албан тушаалтан үйл ажиллагаагаа зөвхөн консулын тойргийн дотор явуулна.Консулын албан тушаалтан тойргийн гадна гагцхүү хүлээн авагч улсын төрийн байгууллагын зөвшөөрлөөр консулын үйл ажиллагаа явуулна.

5.Консулын албан тушаалтан өөрийн үйл ажиллагаагаа явуулахдаа консулын тойргийн эрх бүхий байгууллагатай харилцана. Харин хүлээн авагч улсын зөвшөөрснөөр төвийн эрх бүхий байгууллагатай харилцаж болно.

6.Томилогч улсын иргэн консулын газрын гишүүн хүлээн авагч улсад өөрийн албан үүргээс гадуур худалдааны буюу мэргэжлийн бусад ямар нэг үйл ажиллагааг эрхлэн явуулах ёсгүй.

7.Консулын газрын гишүүд хүлээн авагч улсын дотоод хэрэгт оролцох ёсгүй.

Хорин зургадугаар зүйл

Томилогч улсын улс, иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах

I.Консулын албан тушаалтан томилогч улс болон түүний иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрхтэй.

2.Томилогч улсын иргэн эзгүй байх буюу хүндэтгэх бусад шалтгаанаар өөрийн эрх, ашиг сонирхлоо хүлээн авагч улсад цаг тухайд нь хамгаалж чадахгүй болсон үед консулын албан тушаалтан хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагын өмнө консулын тойрогтоо уг иргэнийг төлөөлөх буюу зохих төлөөлөгчийг томилох эрхтэй.Энэ нь уг иргэн өөрийгөө төлөөлөх хүнийг томилох буюу эрх, ашиг сонирхлоо өөрөө хамгаалах хүртэл үргэлжилнэ.

3.Консулын албан тушаалтан энэ зүйлийн 2-т заасан үйл ажиллагааг явуулахдаа хүлээн авагч улсын хууль тогтоомжийг баримтална.

Хорин долдугаар зүйл

Иргэний харьяалал, паспорт, визтэй  
холбогдсон хүсэлт болон иргэний гэр  
бүлийн байдлын бүртгэл

I.Консулын албан тушаалтан консулын тойрогтоо дор дурдсан эрх эдэлнэ:

а/томилогч улсын хууль тогтоомжийн дагуу иргэний харьяаллын асуудлаар гаргасан аливаа өрөгдлийг хүлээн авах,

б/томилогч улсын иргэдийн тоо бүртгэлийг хөтлөх,

в/паспорт болон орох, орох-гарах, дамжин өнгөрөх виз, бусад баримт бичгийг олгох, шинэчлэн олгох, хүчингүй болгох, түүнчлэн тэдгээрт өөрчлөлт оруулах,

г/томилогч улсын иргэдийн төрөлт болон нас баралтыг бүртгэх,

д/хүлээн авагч улсын хууль тогтоомжид харшлахгүй бол гэрлэгсэд хоёулаа томилогч улсын иргэн байвал тэдний гэрлэлт болон гэрлэлт цуцалсныг бүртгэж зохих бичиг баримт олгох.

2.Энэ зүйлийн I-ийн заалт нь хүлээн авагч улсын хууль тогтоомжийг биелүүлэх үүргээс холбогдох хүмүүсийг чөлөөлөхгүй.

Хорин наймдугаар зүйл

Нотариатын үйл ажиллагаа

I.Консулын албан тушаалтан консулын тойргийнхоо дотор томилогч улсын хууль тогтоомжийн дагуу, хүлээн авагч улсын хууль тогтоомжид харшлахгүй бол нотариатын дорхи үйлдэл, баталгааг хийнэ:

а/томилогч улсад хэрэглэхэд зориулж аль ч улсын иргэний хүсэлтээр бичиг баримтыг олгоно,

б/томилогч улсын гадна хэрэглэхэд зориулж мөн улсын иргэдийн хүсэлтээр бичиг баримтыг олгоно,

в/томилогч улсын буюу хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас олгосон бичиг баримтын гарын үсэг, тамгыг батална,

г/томилогч улсын болон хүлээн авагч улсын албан хэл дээр бичиг баримт орчуулах, орчуулгын үнэн зөвийг гэрчилнэ,

д/томилогч улсын хууль тогтоомжид заасан нотариатын бусад үйлдэл хийж болно.

2.Энэ зүйлийн I-д заасны дагуу консулын албан тушаалтны үйлдсэн, нотолсон буюу орчуулгын үнэн зөвийг гэрчилсэн бичиг баримт хүлээн авагч улсын хууль тогтоомжид харшлахгүй бол тэр улсын зохих эрх бүхий байгууллага, албан газраас түүнийг үйлдсэн, нотолсон буюу орчуулгын үнэн зөвийг гэрчилсний нэгэн адил хууль зүйн ач холбогдолтой, нотлох хүчинтэй байна.

## Хорин есдүгээр зүйл

### Эд хөрөнгө өвлөх, өв хөрөнгийг хамгаалах

1. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага томилогч улсын иргэн нас барсан тухай болон түүний өвлөгдөх эд хөрөнгө, өв залгамжлагч, хувь авагч, гэрээслэлийн тухай мэдээг аль болох богино хугацаанд томилогч улсын консулын албан тушаалтанд мэдэгдэж байна. Хэрэв консулын газар хүсвэл нас барсны гэрчилгээ буюу нас барсныг нотлох бичиг баримтын хуулбарыг өгнө.

2. Хэрэв томилогч улсын аль нэг иргэн өв залгамжлагч буюу хувь авагчийн хувьд нас барсан аль нэг улсын иргэний хүлээн авагч улсад байгаа эд хөрөнгийг өв залгамжлах буюу хувь авах эрхтэй бөгөөд томилогч улсын уг иргэн хүлээн авагч улсад байхгүй бол хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага уг иргэний өвлөх буюу хувь авах эд хөрөнгийн тухай консулын газарт мэдэгдэнэ.

3. Консулын албан тушаалтан томилогч улсын иргэний өв залгамжлалын талаар дор дурдсан үйл ажиллагааг явуулах эрхтэй бөгөөд уг эрхийг өөрөө буюу бүрэн эрхт төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэгжүүлж болно:

а/хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага өвлөгдөх эд хөрөнгийг бүртгэх, холбогдох протоколыг үйлдэхэд оролцох,

б/өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах зорилгоор хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагатай харилцах,

в/хүлээн авагч улсад оршин суудаггүй томилогч улсын иргэн мөн улсад түр хугацаагаар байх үедээ нас барж эд хөрөнгө нь үлдсэн тохиолдолд түүний төрөл садан болон төлөөлөгч хүлээн авагч улсад байхгүй бол консулын албан тушаалтан түүний мөнгө, бичиг баримт, эд хөрөнгөтэй холбогдолтой асуудлыг томилогч улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

4.Томилогч улсын иргэн өвлөгдөхгүй хөдлөх эд хөрөнгийг хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт үлдээж нас барвал түүнийг томилогч улсын консулын албан тушаалтанд шилжүүлнэ.

5.Томилогч улсын иргэн хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт байгаа ямар нэг эд хөрөнгийг өвлөх эрхтэй байгаа буюу өвлөх эрхтэй гэж өөрийгөө үзэж байгаа тохиолдолд хэрэв уг иргэн өөрөө, эсвэл түүний төлөөлөгч өв залгамжлах нэхэмжлэлийг шүүхэд гаргаж шүүхийн ажиллагаанд оролцож чадахгүй бол консулын албан тушаалтан уг иргэнийг хүлээн авагч улсын шүүх буюу эрх бүхий бусад байгууллагын өмнө шууд, эсвэл өөрийн төлөөлөгчөөр дамжуулан төлөөлж болно.

6.Хүлээн авагч улсад байхгүй өв залгамжлагч буюу хувь авагч томилогч улсын иргэнд өвлөгдөх эд хөрөнгө, түүнийг борлуулсан мөнгийг уг иргэнд олгохоор хүлээн авагч улсын шүүх буюу эрх бүхий бусад байгууллагаас шийдвэрлэсэн бол тэрхүү эд хөрөнгө, түүнийг борлуулсан мөнгийг уг иргэнийг төлөөлж байгаа томилогч улсын консулын албан тушаалтанд шилжүүлэн өгнө.

7.Томилогч улсын иргэний эд хөрөнгө хамгаалалтгүй үлдэхэд хүрвэл консулын албан тушаалтан уг эд хөрөнгийг хамгаалах хүнийг томилж болно.

8.Томилогч улсын консулын албан тушаалтан энэ зүйлийн 3, 4, 5, 6, 7-гийн заалтыг хэрэгжүүлэхдээ хүлээн авагч улсын хууль тогтоомжийг баримтална.

Гучдугаар зүйл

Асран хамгаалагч буюу харгалзан  
дэмжигч томилох

1.Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага консулын тойрогт байгаа эрхийн чадваргүй буюу эрхийн хязгаарлагдмал чадвартай томилогч улсын иргэнд хүлээн авагч улсын хууль тогтоом-

жийн дагуу асран хамгаалагч буюу харгалзан дэмжигч томилох шаардлагатай гэж үзвэл энэ тухайгаа консулын газарт мэдэгдэх ёстой.

2. Консулын албан тушаалтан эрхийн чадваргүй буюу эрхийн хязгаарлагдмал чадвартай томилогч улсын иргэний эрх, ашиг сонирхлыг хүлээн авагч улсын хууль тогтоомжид зөвшөөрөгдсөн хүрээнд хамгаалах эрхтэй бөгөөд шаардлагатай гэж үзвэл түүнд асран хамгаалагч буюу харгалзан дэмжигчийн нэрийг дэвшүүлэх буюу томилж болно. Консулын албан тушаалтан асран хамгаалагч буюу харгалзан дэмжигчийн ажиллагаанд хяналт тавих эрхтэй.

Гучин нэгдүгээр зүйл

#### Томилогч улсын иргэдтэй харилцах

1. Консулын албан тушаалтан өөрийн улсын иргэнтэй уулзаж харилцах, түүнд зөвлөлгөө өгөх, хүлээн авагч улсын хууль тогтоомжийг хүндэтгэхийг оролцуулан бүх талын тусламж дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар арга хэмжээ авч болно.

2. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага томилогч улсын иргэнийг баривчилсан буюу бусад ямар нэг хэлбэрээр саатуулсан тухайгаа баривчилсан буюу саатуулснаас хойш 7 өдрийн дотор томилогч улсын консулын албан тушаалтанд мэдэгдэнэ.

3. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага томилогч улсын иргэнийг баривчилсан буюу бусад ямар нэг хэлбэрээр саатуулсан, эсвэл шоронд хорьж байгаа бол томилогч улсын консулын албан тушаалтан уг иргэнийг баривчилсан буюу саатуулсныг мэдэгдсэнээс хойш 3 өдрийн дотор түүнтэй уулзаж харилцах, түүнд эрх зүйн туслалцаа үзүүлэх эрхтэй, консулын албан тушаалтан түүнтэй зохих хугацаанд тогтмол уулзаж болно.

4. Консулын албан тушаалтан хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дээр сураггүй алга болсон томилогч улсын иргэнийг эрэн сурвалжлахад хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас

туслалцаа хүсэж болно. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага уг иргэнтэй холбогдох зүйлийг аль болохоор мэдэгдэнэ.

5. Хүлээн авагч улс томилогч улсын иргэнийг консулын газартаа очих буюу түүнтэй холбоо тогтооход нь ямар нэг хэлбэрээр саад тотгор учруулж болохгүй.

Гучин хоёрдугаар зүйл

Томилогч улсын агаарын хөлөгт  
тусламж үзүүлэх

1. Консулын албан тушаалтан хүлээн авагч улсын нисэх онгоцны буудалд байгаа буюу агаарт нисч яваа өөрийн улсын агаарын хөлөгт консулын тойргийнхоо дотор бүх талын шаардагдах туслалцаа үзүүлэх эрхтэй.

2. Консулын албан тушаалтан өөрийн улсын агаарын хөлгийн дарга болон багийн гишүүдтэй харилцаж болно.

3. Консулын албан тушаалтан өөрийн улсын агаарын хөлөг, түүний дарга болон багийн гишүүдийн талаар гүйцэтгэх үүрэгтэйгээ холбогдсон ямар ч асуудлаар хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагуудаас тусламж хүсч болно.

4. Консулын албан тушаалтан өөрийн улсын агаарын хөлгийн талаар консулын тойргийн дотор дор дурдсан арга хэмжээг авах эрхтэй:

а/хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагуудын эрхэд хохирол учруулахгүйгээр өөрийн улсын агаарын хөлгийн нислэгийн замд болон нисэх онгоцны буудалд байх үед болсон ямар нэг хэрэг явдлыг мөрдөн шалгах, агаарын хөлгийн дарга болон багийн аль нэг гишүүнээс асууж танилцах, хөлгийн бичиг баримтыг шалгах, агаарын хөлгийн нислэг, очих газрын талаар мэдээ хүлээж авах, түүнчлэн агаарын хөлгийг буулгах, нисгэх, буудалд байлгахад шаардагдах туслалцаа үзүүлэх,

б/томилогч улсын хууль тогтоомжид заасан бол хүлээн

авагч улсын төрийн байгууллагуудын эрхэд хохирол учруулахгүйгээр агаарын хөлгийн дарга, багийн аль нэг гишүүний хооронд гарсан аливаа маргааныг шийдвэрлэх,

в/агаарын хөлгийн дарга, багийн аль нэг гишүүнийг эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлэх, эх оронд нь буцаах арга хэмжээ авах,

г/агаарын хөлгийн талаар еерийн улсын хууль тогтоомжийн дагуу аливаа мэдээлэл буюу бусад баримт бичгийг хүлээн авах, үйлдэх буюу гэрчлэх.

Гучин гуравдугаар зүйл

Албаллага, мөрдлөгийн арга хэмжээ  
авах

1. Хүлээн авагч улсын шүүх буюу эрх бүхий бусад байгууллага томилогч улсын агаарын хөлгийн талаар албадлагын ямар нэг арга хэмжээ авах буюу албан ёсны мөрдлөг явуулах гэж байгаа бол энэ тухайгаа томилогч улсын консулын зохих албан тушаалтанд еерийг нь буюу түүний төлөөлөгчийг байлцуулах бололцоо олгох зорилгоор уг ажиллагааг эхлэхээс өмнө мэдэгдэх ёстой. Хэрэв хойшлуулж болшгүй шалтгаанаар ийнхүү урьдчилан мэдэгдэж амжаагүй бол хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага дээрх арга хэмжээг авсныхаа дараа консулын газарт нэн даруй мэдэгдэх бөгөөд мөн консулын албан тушаалтны хүссэнээр авсан арга хэмжээний тухай холбогдох бүх мэдээ сэлтийг түүнд нэн даруй өгнө.

2. Энэ зүйлийн 1-ийн заалт томилогч улсын агаарын хөлгийн дарга буюу багийн аль нэг гишүүний хувьд нэгэн адил хамаарна.

3. Энэ зүйлийн 1, 2-ын заалтыг хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас хийх гааль, хилийн болон аюулгүй байдлын хамгаалалт, хорио цээрийн ердийн үзлэг шалгалт, түүнчлэн агаарын хөлгийн даргын хүсэлтээр буюу зөвшөөрлөөр хийх аливаа үйлдэлд хэрэглэхгүй.

4.Томилогч улсын агаарын хөлөг, түүний баг, зорчигчид хүлээн авагч улсын амгалан тайван, аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг алдагдуулаагүй буюу томилогч улсын агаарын хөлгийн дарга болон консулын албан тушаалтны хүсэлт, эсвэл тэдний зөвшөөрснөөс бусад тохиолдолд хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага томилогч улсын агаарын хөлгийн дотоод хэрэгт оролцож болохгүй.

Гучин дөрөвдүгээр зүйл

АЮУЛ ОСОЛ ТОХИОЛДСОН ҮЕД ТУСЛАМЖ  
ҮЗҮҮЛЭХ

1.Хэрэв томилогч улсын агаарын хөлөг хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт осолдсон буюу мөн улсын нутаг дэвсгэрт осолдсон гуравдахь улсын агаарын хөлөгт томилогч улсын иргэд, тэдний эд хөрөнгө байгааг хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага мэдвэл энэ тухай болон тэдгээр иргэн, тэдний эд хөрөнгийг аврах талаар авсан арга хэмжээний тухай хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага томилогч улсын консулын албан тушаалтанд аль болох богино хугацаанд мэдэгдэнэ.

2.Томилогч улсын консулын албан тушаалтан осолдсон агаарын хөлөг, түүний багийн гишүүд, зорчигчдод бүхий л тусламж үзүүлэх арга хэмжээ авах эрхтэй бөгөөд хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагуудад хандаж дэмжлэг үзүүлэхийг хүсэж болно.

Консулын албан тушаалтан дээр дурдсан тусламж үзүүлэхийн хамт агаарын хөлөгт засвар хийхтэй холбогдсон арга хэмжээ авч болно.Тийм арга хэмжээ авахуулах, цаашид үргэлжлүүлэн хийлгэх хүсэлтийг хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагад тавьж болно.

3.Хүлээн авагч улсын буюу гурав дахь улсын нутаг дэвсгэрт осолдсон томилогч улсын агаарын хөлөг, түүний аль нэг эд анги буюу тээвэрлэж байгаа ачаа хүлээн авагч улсын нутаг дэвсгэрээс олдсон бөгөөд агаарын хөлгийн дарга, агаарын

хөлгийн харьяалагдах байгууллага, түүний төлөөлөгч, холбогдох даатгалын газрын аль аль нь уг агаарын хөлөг, эд юмсыг хадгалж хамгаалах, зохицуулах талаар арга хэмжээ авч чадахгүйд хүрвэл консулын албан тушаалтан тэдгээрийг төлөөлөн дээрх зорилгоор зохих арга хэмжээ авах эрхтэй гэж үзнэ.

4.Энэ зүйлийн 1, 2, 3-т заасан томилогч улсын агаарын хөлөг, түүний эд анги, ачааг хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт худалдах буюу ашиглах зорилгогүйгээр оруулсан бол хүлээн авагч улс гаалийн болон ийм төрлийн бусад татвараас чөлөөлнө.

5.Энэхүү Конвенцийн 32, 33, 34 дүгээр зүйлийн заалт томилогч улсын хөлөг онгоцонд нэгэн адил хамаарна.

## Ү ХЭСЭГ

### ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

Гучин тавдугаар зүйл

#### Конвенцийг соёрхон батлах, хүчин төгөлдөр болгох, үйлчилгээг зогсоох

1.Энэхүү Конвенцийг соёрхон батлах бөгөөд Батламж жуух бичгийг Бээжин хотноо солилцсоны дараа 30 дахь өдрөөс хүчин төгөлдөр болно.

2.Энэхүү Конвенц Хэлэлцэн тохирогч хоёр Талын аль нэг нь түүний үйлчилгээг зогсоох тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа бичгээр мэдэгдсэнээс хойш зургаан сарын хугацаа өнгөртөл хүчин төгөлдөр байна.

Хэлэлцэн тохирогч хоёр Талын бүрэн эрхт төлөөлөгчид үүнийг нотолж энэхүү Конвенцэд гарын үсэг зурж, тамга дарав.

Энэхүү Конвенцийг 1986 оны 8 дугаар сарын 9 -нд  
Улаанбаатар хотноо хятад, монгол хэлээр тус бүр хоёр эх хувь  
үйлдсэн бөгөөд хоёр эх хувь адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ӨМНӨӨС:

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД  
УЛСЫН ӨМНӨӨС:

/ЛЮ ШУЦИН/

/ДАРАМЫН ЁНЦОН/